



# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 591

Улаанбаатар хот

## Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Гадаадад төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” 2010 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 391 дүгээр тушаалын Баясгалангийн Мөнхтулгатай холбогдох хэсгийн “Сиднейн их сургуулийн магистрантурт Байгаль орчны мэдээлэл зүйн чиглэлээр 1 жилийн” гэснийг “Нью Саут Уэйлсийн их сургуулийн магистрантурт Байгаль орчны менежментийн чиглэлээр 2 жилийн”, Цогтсайханы Сантаатай холбогдох хэсгийн “Их Британийн Вант Улсын Йоркийн их сургуулийн магистрантурт Олон улсын харилцаа, аюулгүй байдлын чиглэлээр” гэснийг “АНУ-ын Бриджпортын их сургуулийн магистрантурт Олон улсын харилцааны чиглэлээр” гэж өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР